


Уншигч судлаач та бүхэндээ зориулж “Тогтмол хэвлэлийн сан хөмрөгт” буй Орос сэтгүүлийг цувралаар толилуулж байна. Цуврал №4




“Библиография изобразительного искусства”

сэтгүүл нь ЗХУ-д 6 хоногт нэг удаа гардаг байсан “Книжная летопись” сэтгүүлд 1939 онд хэвлэлээс гарсан дүрслэх урлагийн талаарх ном хэвлэлийн тойм бүртгэл.

Сан хөмрөгт: 1939 №1-4 оны дугаар

“Вестник рентгенологии и радиологии”

сэтгүүл нь рентген оношлогоо, туяаны эмчилгээний талаарх сэтгүүл бөгөөд 1920 оноос гарч эхэлжээ. Эдүгээ Москвагийн Анагаах ухааны Радиологийн холбооны албан ёсны сэтгүүл гэгдэж жилд 6 удаа орос, англи хэлээр хэвлэгдэж гарч байна. Сан хөмрөгт: 1932-1934, 1938-1941, 1954-1984, 1989-1991 оны дугаарууд





“Вестник Академии наук СССР”

сэтгүүл 1931 оны 3-р сараас хэвлэгдэн гарах болжээ. Эдүгээ Оросын ШУА-ийн сар тутмын сэтгүүл болно. Орос, гадаадын эрдэмтэн судлаачдын бүтээл, тайлан, хэлэлцүүлгийг хэвлэн нийтэлж, байгаль, техник, нийгмийн шинжлэх ухааны олон асуудлын талаарх янзын бүрийн үзэл санааг нийтэлдэг. Сан хөмрөгт: 1932-1937, 1939-1991 оны дугаарууд

“Вестник высшей школы”

сэтгүүлийг ЗХУ-ын Дээд, дунд, тусгай боловсролын Улсын хорооноос эрхлэн гаргаж байсан шинжлэх ухаан арга зүйн сар тутмын сэтгүүл. 1940 оноос гарч эхэлсэн ч дайны жилүүдэд буюу 1941-1945 оны хооронд хэвлэгдээгүй юм. Уг сэтгүүл нь боловсрол, шинжлэх ухааны ажил, мөн судлаач, мэргэжилтэн бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх чиглэл болон ЗХУ-ын их, дээд сургуулиудын гадаад харилцаа, дээд боловсролын талаарх олон улсын чиг хандлагын талаарх мэдээллийг нийтэлдэг. Сан хөмрөгт: 1941, 1946-1949, 1952-1959, 1961-1991 оны дугаарууд







"Вестник венерологии и дерматологии"

сэтгүүл 1924 оноос гарч эхэлсэн бөгөөд 1938 оноос энэ нэрээр гарах болжээ. Өнөөдөр тус сэтгүүл Оросын арьс судлалын нэр хүндтэй сэтгүүл гэгдэж биологи, эрүүл мэнд, ялангуяа арьс судлалын чиглэлээр гарсан шинжлэх ухааны хамгийн сүүлийн ололтыг хэвлэн нийтэлж байна. Сан хөмрөгт: 1939-1941, 1947, 1949-1956 оны дугаарууд

"Вестник древней истории"

сэтгүүл нь 1937 оноос ЗХУ-ын ШУА-ийн Түүхийн Хүрээлэн (1968 оноос хойш Дэлхийн түүхийн хүрээлэн)-гээс эрхлэн гаргаж дайны жилүүдэд тасалдаж 1946 оноос үргэлжлэн гарч байгаа эрдэм шинжилгээний сэтгүүл. Эртний дэлхийн түүх, холбогдох салбарыг хамарсан нийтлэл гаргадаг. Сан хөмрөгт: 1939, 1946, 1948-1952, 1956-1991 оны дугаарууд




"Вестник Дальневосточного отделения Академии наук СССР"

сэтгүүл нь 1932 оноос Зөвлөлтийн ШУА-ийн Алс Дорнодын салбар, ШУА-ийн Алс дорнодын Төвийн Шинжлэх ухааны номын сангаас эрхлэн гаргаж байв. Сан хөмрөгт: 1932, 1934-1938 оны дугаарууд

"Вестник Коммунистической академии"

нь Зөвлөлтийн Коммунист Академийн сэтгүүл. Анх (жилд 1922-1923 онд жилд зургаан дугаар гарч байв) "Социалист Академийн мэдээ" нэрээр гарч байв. К.Маркс, Ф.Энгельсийн, В.И.Ленин нарын амьдрал, тэмцлийн тухай, мөн марксизм-ленинизмийн сургааль, нийгэм, эдийн засгийн шинжлэх ухаан, ерөнхий болон ЗХУ-ын түүхийн асуудлыг хөндсөн нийтлэл өгүүллийг хэвлэж байв. Сан хөмрөгт: 1931-1935 оны дугаарууд





“Вестник машиностроения”

сэтгүүл нь ЗХУ-ын СнЗ-ийн дэргэдэх Шинжлэх ухаан, технологийн Улсын хороо, ЗХУ-ын Машин механизм, үйлдвэрлэлийн яам, Машин үйлдвэрлэлийн шинжлэх ухаан, техникийн нийгэмлэгийн төв зөвлөлөөс эрхлэн гаргаж байсан сар тутмын шинжлэх ухаан-техник, аж үйлдвэрийн сэтгүүл. 1921 оноос эхлэн “Вестникметаллопромышленности” нэрээр гарч байв. Тус сэтгүүл нь инженерийн зураг төсөл, тооцоо, машин, механик, зохион байгуулалт, үйлдвэрлэлийн эдийн засаг, технологийн дэвшлийн асуудлыг хөнддөг. 1971 онд хамгийн олон буюу 11,5 мянган хувь хэвлэгджээ. Сан хөмрөгт: 1947, 1948, 1951, 1954, 1956-1958, 1962, 1968-1972, 1977, 1978, 1980, 1991 оны дугаарууд

"Вестник ото-рино-ларингологии"

сэтгүүл 1936 оноос хэвлэгдэн гарч эхэлжээ. Тус сэтгүүл чих хамар хоолойн өвчин, чих хамар хоолойн мэс засал, чих хамар хоолойн хавдар судлал, чих хамар хоолойн эмгэг, нөхөн сэргээх зэрэг чих, хамар, хоолойн чиглэлээрх анагаахын шинжлэх ухааны ололт, практик хэрэглээний асуудлыг голчлон хөнддөг. Сан хөмрөгт: 1939, 1941, 1947-1991оны дугаарууд

